



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

“Ажлын хэсэг байгуулах, зардал батлах тухай” БСШУС-ын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 25-ны А/152 дугаар тушаал батлагдлаа. Энэ тушаалаар

- *Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;*
- *Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;*
- *Шинжлэх ухааны паркийн тухай хуулийн төсөл боловсруулах;*
- *Монгол улсад Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулах;*
- *Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах,*
- *Инновацийн төсөл хэрэгжүүлэх журмын төсөл боловсруулах;*
- *Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын шагналын эрх зүйн орчине боловсронгуй болгох;*
- *Судалгааны нээлттэй лабораторийн үлгэрчилсэн журмын төсөл боловсруулах ажлын хэсгүүдийг тус тус байгуулж, Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийг баталлаа.*

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэхээр БСШУНББХ-ноос байгуулагдсан дэд ажлын хэсгийн гишүүд хуулийн төслийн зарчмийн зөрүүтэй саналд саналын томъёолол, дагалдах хуулийн төсөл, түүний саналын томъёоллыг боловсруулж дууссан. БСШУНББХ-ны тогтоолоор байгуулагдсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дэд ажлын хэсгийн хуралдаанаар саналын томъёололын дагуу хуулийн төсөл дээр ажлын хэсгийн гишүүд санал хураалт явуулж УИХ-ын гишүүдийн ажлын хэсэгт танилцуулахаар бэлэн болгосон.

ХОЁР. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн дүрэмд яамдуудаас санал авч нэгтгэн, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд суурь боловсролын үйлчилгээ үзүүлэх журмын төсөл болон “Сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам”-ын төслийг тус тус боловсруулж байна.

Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хэрэгжүүлэх Мастер төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн дүгнэлээ. Өнөөдрийн байдлаар Мастер төлөвлөгөөний хэрэгжилт 77,7% байна. Бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйл ажиллагааны менежментийг сайжруулах чиглэлд төлөвлөгдсөн үйл ажиллагааны биелэлт сайн байна. Харин салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбогдсон зорилтууд туйлын хангалтгүй хэрэгжиж байна. Мастер төлөвлөгөөнд шинжлэх ухаан, технологийн салбарт олгох улсын төсвийн санхүүжилтийг 2016 онд 0.94 %-д хүргэх зорилт тавьсан боловч өнөөдрийн байдлаар 0,11% байна. Үүнтэй холбогдсон олон зорилт, арга хэмжээ хэрэгжихгүй байна.

Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журмыг шинэчлэх, судалгааны зарим томоохон лабораторийн үйл ажиллагааг судлаачдад нээлттэй журмын төслийг боловсруулан санал авч байна.

Гандбол, Сагсан бөмбөгийн спортын орчин болон сургалтын стандартын ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, стандартын төслийг боловсруулж байна. Ширээний теннис, гимнастик, цана, монгол үндэсний жороо морьны орчин болон сургалтын стандартын ажлын хэсгийн хоёрдугаар хурлыг зохион байгуулж стандарт боловсруулж байна.

ГУРАВ. САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлж буй STEM сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрэглэх арга зүйгээр сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг 4 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулж, үндэсний хэмжээнд нийт 120 сургагч багш бэлтгэлээ.
2. “Сургуулийн өмнөх боловсролын талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлэх арга зам” семинарыг 2017 оны 4-р сарын 18, 19 өдрүүдэд Улаанбаатарт хотод зохион байгууллаа. Семинарт аймаг, нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан бөгөөд дэлхий нийтийн чиг хандлага болон Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр БСШУСЯ-наас баримталж буй бодлого, төлөвлөлт, орон нутагт сургуулийн өмнөх боловсролын бодлогын хэрэгжилт, бэрхшээл, түүнийг шийдвэрлэж буй арга замын талаар хэлэлцлээ.
3. Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн зарим сурагчид сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хүндэтгэн хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон сургууль, багш нараасаа шаардаж гомдол гаргасныг хянах, сургуулийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг тандан судалж дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, асуулга судалгааны үр дүнг нэгтгэх боловсруулах ажлыг гүйцэтгэв. Ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлт сайд, Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох нэгжийн дарга нар болон 29 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчид, багш нарт танилцуулах ажлыг зохион байгуулав.
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Нэгдсэн хорооны бүрэлдэхүүн батлах тухай” 2017 оны А/103, “Төрийн нарийн бичгийн даргын “Олимпиадын зардал батлах тухай” А/72 дугаар тушаалыг тус тус баталж, улсын төрөлжсөн олимпиадын II, III давааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар ханган ажиллаж байна. Улсын төрөлжсөн олимпиадын II даваа аймаг, нийслэлийн хэмжээнд 3 дугаар сард амжилттай зохион байгууллаа. Олимпиадын III даваа 4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 5 дугаар сарын 12-ыг хүртэл зохион байгуулагдах бөгөөд нийт 14 төрлийн хичээлээр 459 багш, 822 суралцагчид мэдлэг, чадвараа сорьж өрсөлдөж байна.

5. 2017 оноос эхлэн хэрэгжүүлэх суурь судалгааны төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Нийт 259 төслийн мэдүүлгийг хүлээн авсан бөгөөд журмын шаардлага хангаагүй 62 төслийг сонгон шалгаруулалтаас хасч 187 төсөлд шинжээч томилон ажиллуулж, дүгнэлт гаргууллаа. Шинжээчийн дүгнэлтээр тэнцсэн 157 төслийг Салбар зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлж, 84 төслийг шалгаруулж, БСШУС-ын сайдын “Суурь судалгааны төсөл батлах, зардал гаргах тухай” 2017 оны 4 дүгээр сарын 14-ний А/124 дүгээр тушаалаар баталгаажуулан, гүйцэтгэгчтэй гэрээ багуулж эхлээд байна.
6. Улсын захиалгаар 2017 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийн сонгон шалгаруулалтын ажил эхлээд байна. Нийт 93 төслийн саналд давхардсан тоогоор 279 шинжээч үнэлгээ өгч, дүгнэлт гаргалаа. Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүгийн аудиториор Улсын захиалгат төслүүдийн өртөг зардлыг тодорхойлж, үнэлгээ, дүгнэлт гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ. Шинжээчдийн дүгнэлтээр олонхийн санал авсан, санхүүгийн аудиторын үнэлгээгээр тэнцсэн төслүүдийг Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.
7. Эрдэм шинжилгээний байгуулагын дэргэд гарааны компани байгуулах 14 инновацийн төслийн хүсэлт эрдэм шинжилгээний байгууллагуудаас ирүүлээд байна. Одоогоор гарааны компани байгуулан хэрэгжүүлэх инновацийн төслийн саналд эхний шатны үнэлгээ дүгнэлтийг журмын дагуу хийж, хэрэгжилт зохицуулалтыг ханган ажиллаж байна.
8. Шинжлэх ухаан, технологийн бодлогын газар, Ерөнхий сайдын дэргэдэх монгол судлалын үндэсний зөвлөл, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/113 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн хамтарсан хуралдаанаар “Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайлан, “Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2017-2021/” төслийн хэлэлцээд, Монгол судлалын үндэсний зөвлөлд танилцуулж, Засгийн газарт хүргүүлэхээр тогтлоо.
9. XIX зууны гүн ухаан, урлах эрдмийн нэрт төлөөлөгч В.Инжиннашийн мэндэлсний 180 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Монгол улсын их сургууль дээр 4 дүгээр сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулав. Хуралд БНХАУ, ОХУ, БНЧУ болон монголын 22 эрдэмтэн оролцож Инжинаннаш судлалын чиглэлээр 20 гаруй илтгэл тавьж хэлэлцүүлэв
10. “Сонгодог урлаг-2” хөтөлбөрийн 2011-2016 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэлээ.

Тус хөтөлбөр нь МУЗГ-ын 2011 оны 157 дугаар тогтоолоор батлагдахдаа нийт 11,8 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэйгээр үндсэн 3 зорилтын хүрээнд 21 зорилгыг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Үүнээс 6,162.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй 72,8%-ийн биелэлттэй ХАНГАЛТТАЙ хэрэгжсэн байна.
11. Засгийн газрын 2017 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан чөлөөт бөхийн “Монголиан опен” олон улсыг тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Чөлөөт бөхийн “Mongolia open-2017” олон улсын уламжлалт тэмцээнийг 7 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Тэмцээн “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулагдаж тэмцээнд БНХАУ, БНСУ, ОХУ, Канад, Казахстан, Венесуэл, Монгол зэрэг долоон орны бөхчүүд хүч үзлээ. Манай улсаас эрэгтэй тамирчдаас Гавьяат тамирчин Г.Мандахнаран, Э.Бэхбаяр, Б.Номин, Б.Гомбодорж, П.Өнөрбат, Н.Золбоо, эмэгтэй тамирчдаас Э.Сумъяа, Э.Гантуяа, С.Батцэцэг, П.Орхон, О.Насанбурмаа, Ш.Түмэнцэцэг нарын шилдгүүд хүч үзэж 10 алт, 6 мөнгө, 16 хүрэл медаль хүртлээ.
12. Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хараа, сонсгол, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх

БСШУС-ын сайдын 2017 оны А/121 тоот ажлын хэсгийн хүрээнд БСШУСЯ, Биеийн тамир, спортын газар, Боловсролын хүрээлэнтэй хамтран “Тусгай сургуулийн биеийн тамирын хичээлийн арга зүйг боловсронгуй болгох нь” сэдэвт сургалтыг тусгай сургуулийн биеийн тамирын багш, нийгмийн ажилтан, дүүргийн биеийн тамирын ХБИ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хөдөлгөөн засалч багш нарын дунд зохион байгуулсан

ДӨРӨВ. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

УИХ-аар 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан салбарын тодотгосон төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарийг нэгтгэж боловсруулж Сангийн сайдад хүргүүллээ. Тодотгосон төсвөөр салбарын нийт төсөв батлагдсан төсвөөс 225.0 сая төгрөгөөр буурсан боловч улсын төсвөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөв 7.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Гадаадын зээл, тусламжаар санхүүжих төсөл, хөтөлбөрийн 2017 онд хийгдэх санхүүжилт нийт 6.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудасанд 34 мэдээлэл байршуулаад байна.

ТАВ. ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Тус яамны 2017 оны эхний улирлын ажлын тайланг 4 сарын 3ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын дэргэдэх нэгжийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, “Төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” тушаалыг батлуулан ажиллалаа.

БСШУС-ын салбарт 2016 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлогын иргэдийн амьдралд үзүүлсэн нөлөөг судалж үнэлгээ өгөх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, судалгааны ажлын дүнг 4 сарын 26 ны өдөр хүлээн авлаа.

Иргэний гомдлын мөрөөр Монголын үлэг гүрвэлийн музейн үйл ажиллагаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын баталсан БСШУС-ын сайдын 2017 оны 03 дугаар сарын 07 өдрийн баталсан 09 дүгээр бүхий удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ